



**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2016 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар

**Зүүн бүсийн аймгуудад зоонозын халдварын эрсдлийг
үнэлэх, үйл ажиллагааны бэлэн байдалд хяналт хийх,
зөвлөн туслах тухай**

Монгол улсын Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 86 дугаар тушаал, Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны "Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дүрэм" батлах тухай 17 дугаар тушаалын 4.2.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Зүүн бүсийн аймгуудад зоонозын халдварын эрсдлийг үнэлэх, үйл ажиллагааны бэлэн байдалд хяналт хийх, зөвлөн туслах ажлыг батлагдсан удирдамжийн дагуу чанартай гүйцэтгэхийг Ажлын хэсгийн ахлагч, Чанар, хяналт үнэлгээ дотоод аудитын албаны дарга /Э.Тунгалаг/-д даалгасугай.
2. Батлагдсан удирдамжийн дагуу шаардагдах томилолт, шатахууны зардал, хэрэгцээт эд зүйлсээр хангаж ажиллахыг Санхүү, эдийн засаг, хангамж үйлчилгээний албаны дарга /З.Ууганцэцэг/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, хүний нөөц, статистикийн албаны дарга /Д.Цэрэнноров/-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Н.ЦОГБАДРАХ